БАТЛАВ
АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Б.ЦЭРЭННАДМИД

АРХАНГАЙ АЙМАГ ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН
НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЗАМ, ТАЛБАЙН НОГООН БАЙГУУЛАМЖИЙГ
НЭМЭГДҮҮЛЭХ, ХЭЛБЭРЖҮҮЛЭХ, АРЧЛАЛТ ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР

2023 оны 03 сарын 25-ны өдөр

Цэцэрлэг хот

1.	Төсөл боловсруулах үндэслэл:	2023 оны аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруултын жагсаалтын 25 дугаарт төсөл арга хэмжээ болох Цэцэрлэг хотын авто замын засвар, тохижилт, гэрэлтүүлэг төсөл арга хэмжээнд тусгагдсаны дагуу
2.	Барилга байгууламжийн нэр , Байршил, одоогийн байдал:	Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нийтийн эзэмшлийн талбайн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хэлбэржүүлэх, арчлалт хийх.
3.	Зориулалт, хүчин чадал:	Эрдэнэбулган сумын нийтийн эзэмшлийн талбайдад болон Булган уулын хамгаалалтын талбай, Бөхбилэгтийн цэцэрлэгт хүрээлэн, Жамъян аваргын сад, Дампил баатрын сад, Барилгачдын нэрэмжит сад, Нутгийн удирдлагын ордны 4 талын сад, Эрх чөлөөний цэцэрлэгт хүрээлэн, Наран төвөөс 24-н тойрог хүртэлх замын 2 талын сад зэрэг цэцэрлэгт хүрээлэн, гудамж талбайд одоо ургаж буй мод бут сөөгийг хэлбэржүүлэх, танах, шуух, усалж арчлах, нөхөн тарилт хийх, шаардлагатай талбайд олон настын үрээр зүлэгжүүлэлт хийх, цэцгийн мандал үүсгэх.
4.	Төслийн хүрээнд хийгдэх ажлууд:	❖ Хайлаас, шар хуайс, гүйлс, нохойн хошуун нийт 850 метр урт ургамлан хашлагыг хайчилж, хэлбэржүүлэх, /5-6 удаа/ ❖ Бүлээр таригдсан 300 орчим мод, бут, сөөгийг тайрах, хэлбэрт оруулах, шуух. /5-6 удаа/ ❖ Нийт талбайн ургах чадвараа алдсан, гэмтсэн мод, бут, сөөгийг нөхөж тарих./шар хуайм, хайлаас, гүйлс, мөнгөлөг улиас, гацуур, агч зэрэг мод бут

		тарина/ ❖ Нийт талбайн ургаж буй мод, бут, сөөгийн хаврын цэнэг усалгааг 4 дүгээр сарын 20-ноос эхлэн 5,6,7 дугаар саруудад 7 хоног тутам усалж, бордох. ❖ Зөөврийн гоёлын бут 10 ширхэг бэлтгэх. /80х80х60 см хэмжээтэй 10 ширхэг модон хайрцаг бэлтгэн хөнгөн хөрсөөр дүүргэж 80 см-ээс дээш өндөртэй гоёлын бут суулгац тарих/ ❖ Зөөврийн гоёлын цэцэг 10 ширхэг бэлтгэх. /20х20х20 см хэмжээтэй 10 ширхэг төмөр торон сав бэлтгэн цэцэг тарих/ ❖ Аймгийн төвд 2-3 байршилд шинээр цэцгийн мандал үүсгэх. ❖ Аймгийн төвийн улсын болон орон нутгийн чанартай авто зам дагуух ногоон зурвасын бүх талбайд олон настын 1-р сортын үрээр тарилт хийж, усалж ургуулах.
5.	Төсөл зохиох үе шат:	Төслийг 1 үе шаттай гүйцэтгэнэ.
6.	Хөрөнгө оруулагч (захиалагч) байгууллага:	Архангай аймгийн ЗДТГазар, Газрын харилцаа, Барилга, Хот байгуулалтын газар
7.	Ногоон байгууламжийн арчилгаа тавих ерөнхий шаардлага:	❖ Мод, сөөг ургамлын үндэсний систем орчмыг дулаалах, хүйтэнд тэсвэргүй бутлаг ургамлыг баглаж уях, дулаанд дуртай ургамлыг хучих, бүтээх, гэмтсэн болон өгөршиж хатсан мод, бут, сөөгийг тухай бүрд нь тайралт, таналт хийнэ. ❖ Гоёл чимэглэлийн төрхөө алдсан, өгөршиж хатсан, ургалт зогссон модлог болон сөөглөг ургамлыг үндсээр нь цэвэрлэнэ. ❖ Мод, сөөг ургамлыг бордох, услах, хөрсийг сийрүүлэх, хог ургамлыг устгах, цэвэрлэгээний болон залуужуулах, хэлбэржүүлэх огтлол, өвчин хортонтой тэмцэх, ургамал хамгааллын цогц ажилбарыг технологийн дагуу үе шаттайгаар хийж гүйцэтгэнэ. ❖ Хөрсний нягтаршлыг арилгах, модны их биеийн ойролцоох хог ургамлыг устгах зорилгоор жил бүр модлог ургамалд 5-10 см, сөөглөг ургамалд 3-5 см гүнд үндэсний системийг гэмтээхгүйгээр хөрс

		сийрүүлэлтийг хийнэ ❖ Гудамж, зам, талбай, өргөн чөлөө, нийтийн цэцэрлэг, авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр хүрээлэгдсэн модлог ургамлыг арчлахдаа титмийг зориулалтын угаалгын бодисоор шүршиж угаана. ❖ Зүлгийн талбайн хөрсийг сийрүүлэх, бордох, услах, самнах, хог ургамлыг түүх, хог хаягдал болон унасан навчийг цэвэрлэнэ. ❖ Мод сөөгт намрын улиралд ургалт зогссон үед тайралт, таналт хэлбэржүүлэлтийг дараа оны 2 дугаар сараас 4 дүгээр сарын эхэн үе хүртэл, мөн найлзуурын өсөлт зогсож, моджиж эхэлсэн 7 сарын дунд үеэс хойш хийнэ. ❖ Модыг тайрч танах ажиллагаа нь титмийг хэлбэршүүлэх, залуужуулах болон цэвэрлэгээний гэсэн гурван үндсэн чиглэлээр хийнэ. ❖ Хэлбэржүүлэх огтлолыг модны титмийг хэлбэршүүлэх, ижилсүүлэн жигдрүүлэх, намхан модыг өндөр болгон, титмийн хувьд бусдыгаа гүйцэх зорилгоор хийнэ. ❖ Тайралт хийхэд удаан ургалттай модны сүүлийн жилийн өсөлтийн 25-50%-ийг, түргэн ургалттай модны сүүлийн жилийн өсөлтийн 70-80%-ийг тайрч танана. ❖ Хэлбэржүүлэлт сайн даадаг модонд эрчимтэй тайралт таналт хийх боловч модыг бүрмөсөн нүцгэлж болохгүй.
8.	Байгаль орчны үнэлгээ:	Шаардлагагүй
9.	Эдийн засгийн тооцоо, төсөв, ТЭЗҮ:	Төсвийг ISTIMATOR pro программ дээр -БНбД 81-95-12 "Барилгын төсөв зохиох дүрэм" -БНбД 81-94-12 "Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм"-г баримтлан мэргэшсэн болон тэргүүлэх төсөвчнөөр гүйцэтгүүлнэ.
10.	Ойролцоо төсөвт өртөг	60,000.000 төгрөг

БОЛОВСРУУЛСАН:
АЙМГИЙН ЗДТГ-ЫН
ХБТХОХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН . . . . . /Л.ЛХАСҮРЭН/